



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1629 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 106,200,000 (нэг зуун зургаан сая хоёр зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэгдэл өртөггүй 2 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв (З.Балданнугар)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв (З.Балданнугар)-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэст, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.МОНХБАЯР



1150500021

ДАНХӨХПТУШААЛ word 2024\Нанжид.docx

Нийслэлийн Өмчийн харилцааны тазрын даргын
2024 оны 01. дүгээр сарын 15-ний өдрийн
104 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгсэл

№	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн он, Монголд ашиглаж эхэлсэн оно	Арлын дугаар	Балансын үнэ	Хуrimтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Сэлбэг буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах доод үнэ (төгрөг)
1	2	3	4	5	6	7	8	9
1	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв	Хьюндай старекс 38-12 УНП	2012/2012	KMJWA37KACU48423	66,300,000	66,300,000	0.00	800,000
2		Хьюндай старекс 34-09 УНЧ	2011/2012	KMJWA37RABU369645	39,900,000	39,900,000	0.00	500,000
Дүн					106,200,000	106,200,000		